



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

Биндэр сумын Засаг даргын тамгын газрын
Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент,
малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтний
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /57/ авсан Гомбосүрэнгийн Нямдолгорыг Биндэр сумын Засаг даргын тамгын газрын Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Г.Нямдолгорыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Биндэр сумын Засаг даргын тамгын газрын дарга /Г.Өнөболд/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Биндэр сумын Засаг даргын тамгын газрын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР